

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/19

Арвайхээр сум

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1., Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 10/03 дугаар тогтоолын 3,1.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн эрүүл мэндийн салбарт дутагдалтай, нэн шаардлагатай мэргэжлээр ирж ажиллах эмч, мэргэжилтнүүдийг аймагт ажиллах хугацаанд нь орон байраар хангах зорилгоор “Орон сууц түр эзэмшүүлэх журам”-ыг **нэгдүгээр** хавсралтаар, комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг удирдлага арга зүйгээр ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Н.Оюунтуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ШИВААННҮРДЭВ



Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 07 дугаар сарын 18-ны
өдрийн 419 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



“ОРОН СУУЦ ТҮР ЭЗЭМШҮҮЛЭХ ЖУРАМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн салбарт ажиллах нэн шаардлагатай нарийн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн дутагдалтай, тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа гол нөлөөлөх шалтгааны нэг нь ажиллаж, амьдрах ая тухтай орон байраар төдийлөн хангагдахгүй явдал нь тулгамдсан асуудал болж байна гэж үзсэн. Тус асуудлыг шийдвэрлэхэд аймаг орон нутгийн удирдлагууд дэмжлэг үзүүлж, аймгийн ИТХ-ын шийдвэрээр Арвайхээр суманд 5 орон сууц ашиглалтад өгөхөөр шийдвэрлэсэн. /2 орон сууц ашиглалтад орсон, 3 орон сууц хүлээгдэж байна. / ашиглалтанд орсон орон сууцуудад энэхүү журам хэрэгжинэ.

Эрүүл мэндийн газрын хөрөнгийн бүртгэлд Арвайхээр сумын 48 айлын орон сууцанд 1 өрөө 1 байр бүртгэлтэй Эрүүл мэндийн газар хариуцан ажиллаж, холбогдох албан хаагчдад түр эзэмшүүлж байгаа.Эдгээр 6 орон сууцанд орон нутагт ажиллахаар ирсэн орон байр байхгүй нэн шаардлагатай нарийн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ая тухтай тайван тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн баталгааг хангах зорилгоор орон сууц түр эзэмшүүлэх харилцааг зохицуулахад чиглэгдэнэ.

Хоёр. Орон сууц түр эзэмшүүлэх нөхцөл

2.1. аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 10/03 дугаар тогтоолын 3,1.2 дах заалтыг үндэслэн нэн шаардлагатай, дутагдалтай байгаа нарийн мэргэшлийн эмч, мэргэжилтэнүүд ажиллах хугацаандаа орон сууц түр эзэмших дэмжлэгт (Эх барих эмэгтэйчүүдийн их эмч, хүүхдийн их эмч, дүрс оношилгооны их эмч, эмгэг судлалын эмч, нэн шаардлагаар ирсэн сувилагч, бусад мэргэжилтэн нар) хамрагдана.

2.2.Аймгийн эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүдэд зориулсан орон сууцанд журмын 2.1-т заасан эмч, мэргэжилтнүүдийг хамруулна. Тухайн эмч, мэргэжилтэн

байраар хангагдсан, эсвэл эмч, мэргэжилтэн ирээгүй үед, Эрүүл мэндийн газрын орон байргүй байгаа албан хаагчдад түр эзэмшүүлэх гэрээ байгуулж болно. Нэн шаардлагатай эмч, мэргэжилтэн ирсэн тохиолдолд 7-10 хоногийн өмнө орон байрыг хүлээлгэж өгөхийг мэдэгдэнэ.

2.3. Журмын 3 дахь заалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлж, тавигдсан шаардлагыг хангасан тохиолдолд байр хүлээлцэх комиссын бүрэлдэхүүн, орон сууцыг түр эзэмшигчид хүлээлгэн өгөхдөө тэмдэглэл хөтлөн, зураг авч баримтжуулан, байрны түлхүүрийг гардуулж өгнө.

2.4. Эдгээр 6 орон сууцанд нэн шаардлагатай эмч, мэргэжилтэн байрласан, өөр байр байхгүй тохиолдолд журмын 2.1-т заасан эмч, мэргэжилтэн ирвэл, орон сууцанд ижил хүйсийн эмч, мэргэжилтнүүдийг хамт оруулж болно. Тухайн нөхцлийг хүлээн авахгүй бол байгуулсан гэрээг цуцлана, мөн гэрээ байгуулахгүй байж болно.

2.5. Орон сууцыг түр эзэмших хугацаа 24 сар хүртэл хугацаатай байна. Сунгах эсэх асуудлыг Эрүүл мэндийн газрын удирдлагын баг, журмын хэрэгжилтийг хангах комиссын хамтарсан хурлаар шийдвэрлэнэ.

Гурав. Орон сууц түр эзэмшихэд бүрдүүлэх бичиг баримт

3.1. Орон сууц түр эзэмших эмч, мэргэжилтэн дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

3.1.1. Иргэний үнэмлэхийн хуулбар /үнэмлэх хүчинтэй байх/

3.1.2. Дээр заагдсан нарийн мэргэжлийн эмчийн диплом

3.1.3. Эмч, мэргэжилтэнг ажиллуулах тухай сул ажлын байрны зарлалд заасан шаардлагад тэнцсэн баримт

3.1.4. Орон нутагт ажиллахаар болсон тохиолдолд байгууллагын тодорхойлолт

3.1.5. Өргөдөл /өөрийн бичгээр гаргасан байх/

3.1.6. Оршин суугаа газрын хаяг, ам бүлийн тодорхойлолт

3.1.7. Өөрийн болон гэр бүлийн өмчлөлийн байшин, эсхүл нийтийн зориулалттай орон сууцгүй болохыг тодорхойлсон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа;

3.2. Эрүүл мэндийн газар нь орон сууц түр эзэмших эмч, мэргэжилтний баримт бичгийн бүрдэл шаардлага хангахгүй эсвэл дутуу бол байрыг хүлээлгэн өгөхгүй.

3.3. Орон сууц түр эзэмших хүсэлт гаргасан эмч, мэргэжилтэн хамтран орон сууц түр эзэмшигчтэй байж болох бөгөөд энэ тохиолдолд хамтран түрээслэгч нь энэ журмын 3-д заасан бүх нөхцөлийг мөн адил хангасан байна.

Дөрөв. Орон сууц түр эзэмшигчийн өргөдлийг хянан шийдвэрлэх, зохих хариу өгөх

- 4.1. Эрүүл мэндийн газрын орон сууц түр эзэмшүүлэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн эмч, мэргэжилтний гаргасан өргөдлийг байгууллагын удирдлагад танилцуулж, судалж, шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.
- 4.2.Өргөдлийг шийдвэрлэхдээ байгууллагын удирдлагын баг болон комиссын бүрэлдэхүүн оролцсон 3-аас доошгүй гишүүний оролцоотойгоор байлцаж, хянан үзэж, зохих шийдвэр гаргана.
- 4.3. Байгууллагын удирдлагын баг, комиссын бүрэлдэхүүн журмын 3-т заасан бүрдүүлэх баримт бичгийн шаардлагыг хангаж байгааг эсэхийг хянан үзэж, холбогдох эрх бүхий байгууллагаас нэмэлт лавлагаа, тодруулга авч болно.
- 4.4. Эмч, мэргэжилтэнд орон сууцыг түр эзэмшүүлэх шийдвэр гарсан үед орон сууцны журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн, эмч, мэргэжилтэнд мэдэгдэж, тухайн эмч мэргэжилтэн байрыг биечлэн үзнэ.
- 4.5. Орон сууцыг биечлэн хүлээлцсэний дараа 2 тал гэрээг бичгээр байгуулна.
- 4.6.Орон сууцыг эзэмшихээр хүлээн авч байгаа эмч, мэргэжилтнийг биечлэн ирүүлж, гэрээг уншиж танилцуулан, харилцан гарын үсэг зурж, Эрүүл мэндийн газрын тамга дарж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр хэрэгжих болно. Тус гэрээг 2 хувь үйлдэж, эзэмшигчид 1 хувийг биечлэн хүлээлгэн өгнө.
- 4.7. Орон сууцыг эзэмшигч гэрээ сунгах хүсэлт гаргасан тохиолдолд ажиллаж буй байгууллагын удирдлагын ажлын чанар үр дүн, харилцаа хандлага, ёс зүй, харилцаа хандлагын байдлыг албан бичгээр тодорхойлолт гаргуулан авч, орон сууцанд амьдарч байх хугацааны хувь хүний хариуцлага зэргийг харгалзан үзэж, дахин 1 удаа, 12 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.
- 4.8. Эмч, мэргэжилтэнд өргөдлийн хариуг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.

Тав.Орон сууц түр эзэмшигчийн эрх, үүрэг

- 5.1. Эмч, мэргэжилтэн орон сууцыг түр эзэмшиж хугацаа 24 сар хүртэл байна. Орон сууцны бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
- 5.2. Гал түймэр, ус алдах, гэмт хэрэг зөрчил гаргах эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.
- 5.3.Орон сууцанд согтуурах ундаа хэрэглэж бусдын амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байна.
- 5.4.Эзэмшигч амьдарч байх хугацааны СӨХ, цахилгаан, интернэт, дулаан халаалт, усны төлбөрийг бусад төлбөрийг хугацаанд нь харицлагатай бүрэн төлөх, байрнаас гарахдаа байрны төлбөрийн тооцоог баримтаар гаргаж хүлээлгэн өгнө.

5.5. Дулаан халаалт, усны хангалт, СӨХ-ийн үйлчилгээ ажлын талаар гарсан зөрчил дутагдлыг хариуцах байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

5.6. Эрүүл мэндийн газраас хамааралтай таагүй байдал, зөрчил дутагдал гарвал тухай бүрд комиссын бүрэлдэхүүнд мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

5.7. Эмч, мэргэжилтэн гэрээнд заасан хугацаанаас өмнө гэрээг өөрийн хүсэлтээр цуцлаж байрнаас гарч болно. Байрнаас гарахдаа комисст мэдэгдэж заавал өөрийн биеэр хүлээлгэж өгнө.

Зургаа. Эрүүл мэндийн газар, орон сууц түр эзэмшигчийн гэрээг цуцлах, хариуцлага

6.1. Орон сууцны өмчлөх эрхийн бичиг /ордер/, түлхүүрийг Эрүүл мэндийн газрын нийгмийн баталгаа хариуцсан хүний нөөцийн мэргэжилтэнд хадгалуулна. Эмч, мэргэжилтэн орон сууцанд орох болсон нь шийдвэрлэгдсэн тохиолдолд байрны түлхүүрийг авна.

6.2. Эрүүл мэндийн газрын удирдлагууд болон албан хаагчид, комисс бүрэлдэхүүн нь “Орон сууц түр эзэмшүүлэх” журам, гэрээнд зааснаас бусад тохиолдолд эмч, мэргэжилтнийг заасан хугацаанаас өмнө орон сууцнаас гарахыг шаардах, аливаа дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

6.3. Орон сууцыг түр эзэмшигч зөвшөөрөлгүйгээр бусдад түрээслэх, гэр бүлийн нөхөр, хүүхдээс өөр гадны хүн амьдруулахыг хориглоно.

6.4. “Орон сууц түр эзэмшүүлэх гэрээг зөвхөн эрүүл мэндийн салбарын нэн шаардлагатай, нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтэнтэй байгуулна. Авлига ашиг сонирхлыг зөрчлөөс сэргийлэх, танил найз нөхөд, ах, дүүс гэсэн байдлаар хандаж орон сууцыг хэн нэгэнд дур мэдэн амьдруулахыг хориглоно. 1-2 албан тушаалтны шийдвэрээр орон сууцыг эзэмшүүлэхийг хориглоно.

6.5. Орон сууцны журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн, орон сууц эзэмшигчид хяналт тавьж ажиллана.

6.6. Орон сууц түр эзэмшихээр гэрээ байгуулсан эмч, мэргэжилтэн журам, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцална.

6.7. Энэ журмыг зөрчсөн албан хаагчдад зохих хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.8. Журмын 5 дахь хэсэгт заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд орон сууцны эзэмшүүлэгч талын санаачлагаар гэрээг цуцлана.

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 07 дугаар сарын 18-ны
өдрийн 4/19 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

Захиргаа санхүү нийтлэг үйлчилгээний албаны дарга

Гишүүд:

Нийгмийн баталгаа, ёс зүй хариуцсан хүний нөөцийн
мэргэжилтэн

Байгууллагын нягтлан бодогч, нярав